



БАТЛАВ.
ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА
Г.БАТСУУРЬ

.....ОНЫ...ДУГААР.....САРЫН...ӨДӨР



БАТЛАВ.
ДЭЛХИЙН ЗОН МОНГОЛ ОУБ-ИЙН ЗҮҮН
БҮСИЙН ДАРГА ХЭНТИН
БОТӨНЦӨР Д.ОЮУНТУУЛ

2017 ОНЫ 4 ДУГААР 21 САРЫН 21 ӨДӨР

**БАГШИЙН ЁС ЗҮЙН ТАЛААРХ СУРГАЛТ, ХҮҮХЭД НЭГ БҮРИЙГ ХӨГЖҮҮЛЭХ
“НАДАД ТУРШЛАГА БАЙНА” СЭДЭВТ ШИЛДЭГ ТУРШЛАГАТАЙ БАГШ НАРЫН
ЗӨВӨЛГӨӨНИЙ УДИРДАМЖ**

2017.04.21

Зөвөлгөөний зорилго:

- Багш нарт ёс зүйн ахисан шатны сургалт, хэлэлцүүлэг хийх.
- Ерөнхий боловсролын сургуулийн багш, нийгмийн ажилтнуудын “Хүүхэд хөгжүүлдэг шилдэг туршлага”-ыг судлаж, бусад багш нар, орон нутагт түгээснээр хүүхдийг хөгжүүлэх олон талт чадваруудтай болно. Энэ нь хүүхдийн сурах сонирхол, хичээлдээ хандах хандлагад нөлөөлнө.
- Орон нутгийн шилдэг туршлагаас бусад багш ажилтнууд суралцаж, олон хүүхдийг сайн туршлагаар хөгжүүлэх үйл ажиллагаа дэлгэрнэ.
- Багш нарын шилдэг туршлага, арга зүйг ном эмхэтгэл болгон хэвлүүлдэг сайн туршлагатай болно.
- Хүүхдийн сурч боловсрох эрх хангагдах

Зорилт:

1. Бүх багш нарыг хамарсан “Багшийн ёс зүй- хариуцлага” сэдвээр сургалт, хэлэлцүүлэг хийнэ.
2. СӨБ, бага, дунд багш нарын “Надад туршлага байна” шилдэг туршлагаа солилцох, суралцах зөвөлгөөн зохион байгуулна.
3. Орон нутагт хүүхэд хөгжүүлж байгаа шилдэг багш нарын туршлагыг ном болгон хэвлүүлж, багш нар болон сургуулийн сурагчдын хүртээл болгоно.

Зохион байгуулагч:

- Аймгийн Засаг даргын Тамгын газар, Нийгмийн бодлогын хэлтэс, “Боловсролыг дэмжих дэд хөтөлбөр”
- Боловсрол, соёл, урлагийн газар,
- Дэлхийн зөн олон улсын байгууллага Бор-өндөр 1 ОНХХ

Амрах хүрээ: Аймгийн СӨБ, ЕБС, Политехник коллежийн багш нар

Үйл ажиллагаа:

1. Бүх багш нарыг хамарсан “Багшийн ёс зүй- хариуцлага” сэдвээр сургалт, хэлэлцүүлгийг **2017 оны 04 дүгээр сарын 29** – нд Боржигин чуулгад зохион байгуулна.
2. Аймгийн зөвөлгөөнд нэг цэцэрлэгээс 3, сургуулиас бага ангийн 3, дунд болон ахлах ангийн 5 – аас доошгүй багшийн туршлагаа түгээх илтгэл, сайн арга зүйг хэлэлцэнэ.
3. “Надад туршлага байна” туршлага түгээх зөвөлгөөн **2017 оны 05 дугаар сарын 06** – ны өдөр 1 дүгээр сургууль, Боржигин чуулгад зохион байгуулна. Зөвөлгөөнийг СӨБ-бага анги, байгалийн ухаан, нийгмийн ухааны 3 чиглэлээр явуулж, шилдэг илтгэл, арга зүйг бүх багш нарт уншиж, танилцуулна. Зөвөлгөөнд оролцож буй багшийн илтгэлийг бусад бүх багш нар оролцон сонсож, шилдэг туршлагыг шалгаруулна.
4. “Надад туршлага байна” туршлага түгээх зөвөлгөөнд ирүүлсэн шилдэг илтгэлүүдийг эмхэтгэн **2017 оны 5 дугаар сард** багтаан ном болгож хэвлүүлнэ.

Зөвөлгөөний илтгэлийн сэдэв, зохион байгуулалт: Үүнд:

- Багшийн ёс зүйн эерэг харилцаа нь хүүхдийн хөгжилд нөлөөлөх нь
- Хүүхэд бүрийг хөгжүүлэх сургуулийн нийгмийн ажил
- Анги удирдсан багш, эцэг эхийн хамтын ажиллагаа хүүхдийн хөгжилд эерэгээр нөлөөлсөн сайн туршлага
- Хичээлээс гадуурх үйл ажиллагаагаар хүүхэд хөгжүүлж буй туршлага
- Хүүхэд бүрийг хөгжүүлэхэд анги удирдсан багшийн үүрэг, оролцоо
- Хүүхэд бүрийг хөгжүүлэх сайн туршлага, арга зүй
- Анги удирдсан багш сурагчдын хөгжилд ахиц өөрчлөлт гаргасан туршлага
- Хичээлээс гадуурх үйл ажиллагаагаар хүүхэд хөгжүүлж буй туршлага
- Хүүхэд бүрийг хөгжүүлэхэд эцэг эх, орон нутгийн байгууллагын туршлага

Зохион байгуулах үйл ажиллагаа: Хүүхэд нэг бүрийг хөгжүүлэх тэргүүн туршлага, арга зүй бүхий ажлын сайн арга, аргачлал, тэдгээрийн үр дүнг тусгасан илтгэл, танилцуулгыг цахимаар бэлтгэнэ. Багш бүр 5 минутанд багтаан илтгэлээ танилцуулна. Илтгэлд тавигдах техник стандартын шаардлага хангасан байх:

- Илтгэлийн ерөнхий бүтэц:

a. Сэдвийг сонгосон шалтгаан, ач холбогдол

b. Өнөөгийн нөхцөл байдал /дүн шинжилгээ, судалгаа/

c. Дэвшүүлж буй шинэ санаа /туршилт судалгаа/

d. Тулгамдсан асуудлыг шийдвэрлэх, арга зам, боломж нөөц

e. Дүгнэлт

f. Ашигласан эх сурвалж, ном зүй /Хавсралт материалууд байж болно/

- Илтгэлд байх шаардлагатай мэдээлэл

Илтгэгчийн овог нэр, зэрэг цол, цахим хаяг

- Багш нар өөрийн туршлагыг баталгаажуулсан цахим болон фото зураг, бусад хэрэглэгдэхүүнийг авч ирж, үзэсгэлэн гаргаж болно.

Илтгэлийг хүлээн авах, шалгаруулах хугацаа:

Илтгэлийг цаас болон цахим хэлбэрээр аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтэс, Боловсрол, соёл, урлагийн газарт 2017 оны 05 дугаар сарын 01- нд хүлээн авна.

Хүүхэд бүрийн хөгжилд хувь нэмрээ оруулсан шилдэг сайн туршлага, арга зүй, илтгэлийг эмхтгэл болгон хэвлүүлнэ.

Байгууллагуудын багш нарын оролцоо нь тухайн байгууллагын менежерийн үр дүнгийн гэрээний дүгнэх үзүүлэлтэд орж тооцогдоно.

Шагнал урамшуулал

Шилдэг туршлага, арга зүй – 3 –ийг шалгаруулна. Өргөмжлөл, мөнгөн шагналаар шагнаана.

Зөвөлгөөний хүрэх үр дүн:

- Хүүхдийг хөгжүүлэхэд багш, эцэг эх, орон нутгийн хамтын ажиллагаа үр өгөөж дээшилнэ.
- Багшийн ёс зүйн харилцаа хандлагад эерэг өөрчлөлт гарна.
- Багшийн ёс зүй дээшилснээр хүүхдийн эрх ашиг хамгаалагдаж, зөрчигдөхгүй болно.
- Орон нутагтаа байгаа сайн туршлагыг түгээж, хамтдаа хэрэгжүүлнэ.
- Багш нарын хүүхэд хөгжүүлж буй туршлагыг ном болгож түгээх, баримтжуулна.
- Орон нутгийн багш нарын сайн туршлагаас суралцсан багш нар цаашид эрдэм шинжилгээний томоохон хэлэлцүүлэгт хамрагдана.